



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 11-ны өдөр

Дугаар А/60

Эрдэнэт

Г Журам шинэчлэн батлах тухай Т

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Журам, аргачлал батлах тухай" А/605 дугаар тушаал, аймгийн засаг даргын 2021 оны "Журам батлах тухай" А/188 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг нэгдүгээр, эрх зүйн баримт бичгийг тайлагнах хугацааг хоёрдугаар, холбогдох баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмыг хэрэгжүүлэн хангаж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга наарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/74 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын  
2022 оны 03 дугаар сарын  
11.-ний өдрийн 11 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

9043446 2020030036

## АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмыг Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа, Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд мөрдөнө.

1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь териин бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нэлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулж бэхжүүлэх, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийг сайжруулахад оршино.

### Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим, хамрах хүрээ

3.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. шударга, хараат бус байх;

3.1.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, тэдгээрээс гаргасан тайлан, дүгнэлт нь ил тод байх;

3.1.3. хяналт-шинжилгээ, үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

3.1.4. Үр дүнд чиглэсэн байх

3.1.5. хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх;

3.1.6. хяналт-шинжилгээ үнэлгээ хийхдээ хэрэглэгч, оролцогч болон олон нийтийн оролцоог хангасан байх;

### Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

3.1. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн болон тусгайлсан үнэлгээг хийнэ.

3.1.1. Гүйцэтгэлийн ХШУ нь дараах хүрээг хамарна.

3.1.1.1. Аймгийн Засаг даргаас Эрүүл мэндийн газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

3.1.1.2. Байгууллагын ил тод байгууллагын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт

3.1.1.3. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанарын үзүүлэлт

3.1.1.4. Хэрэглэгчийн үнэлгээ

- 3.1.1.5. Төрийн албан хаагчийн сургалт ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
- 3.1.2. Тусгайлсан хяналт шинжилгээ үнэлгээ нь дараах хурээг хамарна.
- 3.1.2.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- 3.1.2.1.1. Монгол Улсын хууль;
- 3.1.2.1.2. Улсын Их Хурлын тогтоол;
- 3.1.2.1.3. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол;
- 3.1.2.1.4. Ерөнхийлөгчийн зарлиг;
- 3.1.2.1.5. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр;
- 3.1.2.1.6. Засгийн газрын тогтоол;
- 3.1.2.1.7. Ерөнхий сайдын захирамж;
- 3.1.2.1.8. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл;
- 3.1.2.1.9. Засгийн газрын болон Ерөнхий сайдын албан даалгавар
- 3.1.2.1.10. Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгавар
- 3.1.2.1.11. Аймгийн Иргэдийн тэргүүлэгчдийн хурлын болон Тэргүүлэгчдийн тогтоол шийдвэр
- 3.1.2.1.12. Аймгийн Засаг даргын албан даалгавар
- 3.1.2.1.13. Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл
- 3.1.2.1.14. Аймгийн Засаг даргын захирамж
- 3.1.2.2. Бодлогын баримт бичигт дараах баримт бичгүүд хамаарна.
- 3.1.2.2.1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- 3.1.2.2.2. Хөгжлийн зорилтот хөтөлбөр
- 3.1.2.2.3. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- 3.1.2.2.4. Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- 3.1.2.2.5. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- 3.1.2.2.6. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
- 3.1.2.2.7. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө
- 3.1.2.2.8. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө
- 3.1.2.3. Байгууллагын удирдлага хөгжил:
- 3.1.2.3.1. Үйлчлүүлэгчид ээлтэй орчин бурдуулэх талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дүн
- 3.1.2.3.2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн
- 3.1.2.3.3. болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний нөхөн сэргээх үеийн төлөвлөгөө, хэрэгжилтийн байдал
- 3.1.2.3.4. Байгууллагын үйлдвэрчний эвлэлтэй хамтран ажилласан байдал, хамтын гэрээний хэрэгжилт
- 3.1.2.3.5. Судалгаа шинжилгээний ажлын хэрэгжилт
- 3.1.2.3.6. Байгууллагын гадаад хамтын ажиллагаа, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслийн үр дүн

3.1.2.3.7. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд мэдээллийн технологийн зохистой хэрэглээг төлөвшиүүлсэн байдал, цахим системийн уялдаа холбоо, үр дүн

3.1.2.3.8. Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн

#### **Дөрөв.Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, зохион байгуулалт**

4.1. Эрүүл мэндийн байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий дотоод хяналтын нэгж, эсхүл ажилтантай байна.

4.2. Эрүүл мэндийн газар нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлыг эрүүл мэндийн салбарын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна.

4.3. Эрүүл мэндийн байгууллагууд хавсралтад заагдсан хугацаанд ирүүлэх бөгөөд ЭМГ-ЫН хэлтэс, НЭМТ-ийн хариуцсан мэргэжилтнүүд нь Эрүүл мэндийн газрын даргын батлагдсан хуваарийн дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж өгөх үүрэгтэй. Бодлогын баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шатанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан, нэгжээс төлөөлөл оруулан хамтран ажиллана.

4.4. Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчид тавих шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан хүнийг бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан тушаалд томилно:

4.4.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр болон тухайн салбарт гурваас доошгүй жил ажилласан туршлагатай байх;

4.4.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр гадаад, дотоодын сургалтад хамрагдсан байх;

4.4.3. Баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх.

4.5. Тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байгууллагын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа тогтоосон хугацаанд хэлэлцүүлж холбогдох байгууллагад хүргүүлнэ.

#### **Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтны эрх, үүрэг**

5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан хаагч нь дараах эрхтэй байна:

5.1.1. Байгууллагын дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцах;

5.1.2. хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээлэл, баримт, материалыг холбогдох нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

5.1.3. хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээр зөвлөмж өгөх, өгсөн зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлах;

5.1.4.хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

## 5.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан хаагч нь дараах үүрэгтэй байна:

5.2.1. хууль тогтоомж, төрийн албаны ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах;

5.2.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад олж авсан баримт, мэдээллийн нууцыг чанд хадгалж зөвхөн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд ашиглах;

5.2.3. хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах;

5.2.4. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгаж, байгууллагын удирдлагын зөвлөлд танилцуулах

## **Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, төрөл, зохион байгуулалт**

### 6.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, төрөл:

6.1.1. захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг батална. Энэхүү төлөвлөгөө нь тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн төлөвлөгөө байж болно. Төлөвлөгөөнд зорилго, зорилт, хамрагдах байгууллага, нэгж, хэрэгжүүлэх хугацаа, зардал, хамтран оролцох байгууллага зэргийг тусгана.

6.1.2. Үнэлгээний зорилгоос хамааруулан үр дүнд суурилсан явцын болон эцсийн үнэлгээ хийх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөнд ямар төрлийн үнэлгээ хийх талаар нарийвчлан тусгана.

6.1.3. Харьяа байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, хамтын ажиллагааны гэрээг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын захирамж болон Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулна. Ажлын хэсгийн ажиллах хэлбэр нь хурал байна. Нийт гишүүдийн дийлэнх олонх оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцож, олонхын саналаар шийдвэр гаргана.

6.1.4. Зайлшгүй шаардлагаар Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргын захирамжаар баталсан удирдамжаар бодлогын тодорхой чиглэлээр төлөвлөгөөт бус хяналтыг хийж болно.

6.1.5. Энэхүү журмын 3.1.2.1, 3.1.2.2-т заагдсан хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг 2-р хавсралтаар тогтоосон хугацаанд 3-р хавсралтын хүснэгтийн 3.1.-3.4 -ийн дагуу гаргаж Эрүүл мэндийн газарт ирүүлсний дагуу нэгтгэн ХШҮ хийж Эрүүл мэндийн газраас Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ.

6.1.6. Энэхүү журмын 3.1.2.3, 3.1.2.4, 3.1.2.5, 3.1.2.6-д заагдсан тусгайлсан ХШҮ-г Эрүүл мэндийн газраас хийж ЭМЯ-нд тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

6.1.7. Тайланд ХШҮ хийхдээ баримт бичиг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг ашиглана.

6.1.8. Жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээ нь шалгуур бүрийн онооны нийлбэрийг нийт шалгуурын тоонд хувааж гаргасан дундаж оноогоор илэрхийлэгдэнэ.

6.1.9. Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХэлтэс дүгнэнэ.

6.1.10. Эрүүл мэндийн салбараар үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан журмын дагуу хийж, нэгтгэн ЭМЯ-нд хүргүүлнэ.

#### **Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:**

6.1. Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараах

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\% \quad \begin{array}{l} \text{аргачлалын дагуу хувиар} \\ \text{илэрхийлэн үнэлнэ;} \end{array}$$

6.2. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараах аргачлалаар тооцно

6.2.1. зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь;

6.2.2. тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь;

6.2.3. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь;

6.2.4. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30 хувь;

6.2.5. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг "0" хувь.

6.3. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг энэ журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцно;

6.3.1. “үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь;

6.3.2. “тодорхой үр дүнд хүрсэн”-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-99 хүртэл хувь;

6.3.3. “эрчимжүүлэх шаардлагатай”-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол 31-69 хүртэл хувь;

6.3.4. “үр дунгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0-30 хүртэл хувь.

6.4. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээг дараах аргачлалаар тооцно:

6.4.1. “бүрэн хэрэгжсэн”-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

6.4.2. “хэрэгжих шатанд”-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь);

6.4.3. “хэрэгжилт хангалтгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-49 хүртэл хувь);

6.4.4. “хэрэгжээгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-9 хүртэл хувь);

6.4.5. “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”.

6.5. Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа зорилт, арга хэмжээ, зүйл, заалт бүрийн хэрэгжилтийн арифметик дунджаар тооцно. Тавьсан зорилтын арга хэмжээ, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулж хувиар илэрхийлнэ.

6.5. Тухайн жилийн үйл ажиллагааны үнэлгээний дүнг гаргахдаа үзүүлэлт бүрийн үнэлгээг 100 хүртэл хувиар илэрхийлэн нийлбэр үнэлгээний арифметик дунджийг харгалзах жинд шилжүүлнэ. Ерөнхий үнэлгээг тодорхойлоходоо жинд шилжүүлсэн дүнгүүдийн нийлбэрийг 0.05-аар үржүүлж, 0-5 хүртэл оноонд шилжүүлэн дүгнэнэ;

Е-ерөнхий үнэлгээ;

В-бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хувь;

β-байгууллагын чиг үүргийн биелэлтийн хувь;

γ-байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ;

-бодлогын баримт бичгийн тоо;

т-байгууллагын чиг үүргийн үзүүлэлтүүдийн тоо;  
к-байгууллагын нээлттэй байдлын үзүүлэлтүүдийн тоо;  
і-үзүүлэлтийн дугаар.

$$E = 0.05 * \left[ \left( \frac{1}{n} \sum_{i=1}^n (\alpha_i) \right) * 0.6 + \left( \frac{1}{m} \sum_{i=1}^m (\beta_i) \right) * 0.2 + \left( \frac{1}{k} \sum_{i=1}^k (\gamma_i) \right) * 0.2 \right]$$

6.6. Засгийн газрын гишүүнээс аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, стратеги төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ бодлогын баримт бичиг үнэлэх аргачлал, байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ тооцдог аргачлалыг тус тус баримтална.

6.7. Хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад тайлagnaадаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаана.

6.8. Ерөнхий үнэлгээний оноог үндэслэн дор дурдсан үнэлгээний аль нэгийг өгнө. Үүнд:

- |                      |                               |
|----------------------|-------------------------------|
| A буюу "Маш сайн"    | 90-100 хувь (4.50-5.00 оноо)  |
| B буюу "Сайн"        | 80-89,0 хувь (4.00-4.49 оноо) |
| C буюу "Хангалттай"  | 70-79,0 хувь (3.50-3.39 оноо) |
| D буюу "Дутагдалтай" | 60-69,0 хувь (3.00-3.59 оноо) |
| F буюу "Хангалтгүй"  | 0-59,0 хувь (0.00-2.99 оноо)  |

#### **Долоо.Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан**

10.1.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийн урсгалыг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээхэд аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн цахим сан (цаашид "цахим сан" гэх)-г ашиглана.

10.2.Хэрэгжилтийн тайланг цахим санд оруулахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах бөгөөд шаардлагатай бол нотлох баримтыг файлаар хавсаргана.

10.4.Цахим санд мэдээлэл оруулж албан хаагч мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцна.

10.5. Эрүүл мэндийн газар дараах асуудлыг хариуцна:

10.5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн болон тухайн асуудал хариусан ажилтан цахим санд нэвтэрч, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргахдаа аймгийн Засаг даргын Тамгын газраас хяналтад авч И-Оффис системээр хүргүүлсэн заалтуудаа хариуцан гаргаж хугацаанд нь системд оруулж тайлагнана.

10.5.2. бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ, тайланг Засаг даргын зөвлөл, агентлагийн даргын хурлаар хэлэлцүүлсний дагуу цахим санд оруулан баталгаажуулж, холбогдох байгууллагад албан бичгээр хүргүүлэх;

10.5.3. холбогдох байгууллагаас өгсөн үнэлгээтэй тухай бүр танилцаж, өгсөн удирдамж, зааврыг мөрдөн ажиллах.

#### **Найм. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх**

11.1 Эрүүл мэндийн байгууллага, албан тушаалтан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланда дурдсан зөвлөмж дүгнэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

11.2. Эрүүл мэндийн удирдлагууд тэргүүний арга, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийн хүртээл болгох, гарсан алдаа, дутагдлыг засах, залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

11.3 Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

11.4. Байгууллагын жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөнд холбогдох дээд газраас өгөгдсөн зөвлөмж, санал, дүгнэлтээр өгөгдсөн арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлнэ.

11.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээг газар дээр нь хийх, эрдэмтэн, судлаачдыг үнэлгээ хийхэд татан оролцуулах, хэрэглэгчийн болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, сургалт зохион байгуулах, сургалтын материал, ном, товхимол, гарын авлага хэвлүүлэх зэрэг зардлыг өөрийн байгууллагын төсөвт жил бүр тусган батлуулна.

#### **Ес. Хариуцлага**

9.1. Үнэлгээний дүнгээр “Дутагдалтай” болон “Хангалтгүй” гэж дүгнэгдсэн байгууллагын удирдлагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

9.2. Дараах зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хуульд зааснаар хариуцлага хүлээлгэнэ:

9.2.1. Энэхүү журамд заасныг зөрчиж худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан, тогтоосон хугацаанд тайлагнаагүй тохиолдолд

9.2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг, тайланг байгууллагын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлээгүй.

Эрүүл мэндийн газрын даргын  
2022 оны 05 дугаар сарын  
11.-ний өдрийн 11 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

9043446 2020030036

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДААС БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ,  
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ,  
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ ХУГАЦАА**

д/д	Тайлангийн төрөл	Тайлан хүлээх авах байгууллага	Тайлан хүргүүлэх хугацаа	Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх хугацаа	Нэгдсэн тайлан хүлээн авах байгууллага	Тайлан хүлээн авах хугацаа
Бодлогын баримт бичиг	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараат 2050"	ЭМГ	06.05 12.03	6.05	ЭМЯ	07.15
	Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл			12.03	Аймгийн ЗДТГ	06.10 12.10
	Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр	ЭМГ	07.15 05.31 12.25	8.10	ЭМЯ	08.15
				06.03 12.08	Аймгийн ЗДТГ	06.05 01.05 06.10 12.10
	Монгол улсыг хөгжлийн жилийн төлөвлөгөө	ЭМГ	5.25 12.25	05.27 12.08	ЭМЯ	06.01 01.01
	Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	ЭМГ	06.05 12.01	06.03 12.03	Аймгийн ЗДТГ ХШУДАХ	06.10 12.05
	Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх Эмч хөтөлбөрийн хэрэгжилт	ЭМГ	12.01	12.08	Аймгийн ЗДТГ НБХ	12.10
	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	ЭМГ	09.10	09.15	Аймгийн ЗДТГ ХОХБТХ	09.20

	Аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө	ЭМГ	09.10		АЗДТГ ХОХБТХ	09.20
Хууль тогтоомж, тогтоол шийдвэр ийн биелэлт	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, УАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт	ЭМГ	05.31 12.05		ЭМЯ	12.20 06.05
	Аймгийн ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийн хэрэгжилт			12.08 06.05	Аймгийн ЗДТГ ХШУДАХ	12.10 06.10
Төсөл	Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлберийн хэрэгжилт	ЭМГ	06.01 12.01	12.05 06.05	Аймгийн ЗДТГ ХШУДАХ	12.10 06.10
	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хамтын хэлэлцээр			12.01 06.05	ЭМЯ	12.10
Бусад	Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт	ЭМГ	12.01 06.05	12.05 06.05	Аймгийн ЗДТГ ХШУДАХ	12.10 06.10
	Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	ЭМГ	12.01 06.05		Аймгийн ЗДТГ ХШУДАХ	12.10 06.10
					Аймгийн ЗДТГ ХШУДАХ	12.10 06.10

Эрүүл мэндийн газрын даргын  
2022 оны 03 дугаар сарын  
11.-ний өдрийн 10 дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт

9043446 2020030036

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ  
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

Хүснэгт 3.1.

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)
				Он	түвшин		
Бодлогын баримт бичгийн зорилго 1							
1.	Зорилт 1						
1.1.	Арга хэмжээ						
1.2.	Арга хэмжээ						
1.3.	Арга хэмжээ						
Бодлогын баримт бичгийн зорилго 2							
2.	Зорилт 2						
2.1.	Арга хэмжээ						
2.2.	Арга хэмжээ						
2.3.	Арга хэмжээ						

## **ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУСНЭГТ**

### Хүснэгт 3.2.

ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт	Арга хэмжээний дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот тувшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)	Хэрэгжилт ийн хувь	
						Он		
						Зорилтот тувшин, үр дүнгийн үзүүлэлт		
1	2	3	4	5	6	7	8	9

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ  
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

Хүснэгт 3.3

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
			Салбар чиглэл: 1		
			1.а. Монгол Улсын хууль		
			1.б. Улсын Их Хурлын тогтоол		
			1.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол		
			1.г. Ерөнхийлөгчийн зарлиг		
			1.д. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл		
			1.е. Засгийн газрын тогтоол		
			1.ё. Ерөнхий сайдын захирамж		
			1.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл		
			1.з. Засгийн газрын албан даалгавар		
			Хэсгийн дундаж: ..... хувь		
			Салбар чиглэл: 2		
			2.а. Монгол Улсын хууль...		
			Хэсгийн дундаж: ..... хувь		
			Нийт дундаж: ..... хувь		

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ  
ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (..... он)**

Хүснэгт 3.4

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	
<b>Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх</b>							
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	Үүнээс	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	-		1. Нэг удаагийн сургалтын хугацаа 4 цагаас дээш бол тайлагнана.	
			Ажлын байран дахь сургалт	-			
			Мэргэшүүлэх сургалт	-			
			Туршлага солилцох арга хэмжээ	-			
		Үүнээс	Бусад	-		2. Зорилтот түвшин хэсэгт байгууллагын сургалтын төлөвлөгөөнд туссан дүнг бичнэ.	
			Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-			
			Эмэгтэй албан хаагч	-			
			Эрэгтэй албан хаагч	-			
		Үүнээс	Удирдах албан тушаалтан	-		3. Гадаад улс орон, хилийн чандад хамрагдсан сургалтыг тайлагнана.	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-			
			Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал:	90-ээс дээш			
			Нийт албан хаагчдад эзлэх хувь				
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	Үүнээс	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-		4. Дэлгэрэнгүй судалгаа мэдээллийг тайланд хавсаргасан байна.	
			Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-			
			Эмэгтэй албан хаагч	-			
			Эрэгтэй албан хаагч	-			
		Үүнээс	Удирдах албан тушаалтан	-		4. Дэлгэрэнгүй судалгаа мэдээллийг тайланд хавсаргасан байна.	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-			
			Гадаад сургалтад хамруулсан байдал:	20-оос дээш			
		3.1.	Нийт албан хаагчдад эзлэх хувь				
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд	-		Тайлант оны гүйцэтгэлээр	

чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн		зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)			
	3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош		

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах

4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	-		Тайлант оны гүйцэтгэлээр
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	-		Хоногт олгохоор тогтоосон дүн
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бурдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш		Асуулгын агуулга, хэлбэр нь жишиг загварт нийцсэн байна
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш		Төрөлжсөн болон багц шинжилгээ
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш		Сайн дураар хамрагдах
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-		Тайлант оны гүйцэтгэлээр

**ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ  
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

Хүснэгт 3.5

№	Шалгуур үзүүлэлт	Хариуцах хэлтэс	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал				
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	УТХ ХШҮМХ ЭТҮХ НЭМТ		
2.	Үйлчилгээ, захидал харилцааны Үйлчилгээнд хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	УТХ		
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	УТХ ХШҮМХ ЭТҮХ НЭМТ		
4.	Үйл ажиллагаандaa мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	УТХ ХШҮМХ ЭТҮХ НЭМТ		
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын	УТХ ХШҮМХ ЭТҮХ		

	шийдвэрийн төслийг цахим хуудсандaa 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	НЭМТ		
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	УТХ ХШУМХ ЭТУХ НЭМТ		
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	УТХ ХШУМХ ЭТУХ НЭМТ		
8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	ЭТУХ ХШУМХ		
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим	УТХ ХШУМХ		

	хуудсандaa байрлуулан тухай бүр шинэчлэх;			
	Хэсгийн дундаж хувь:			
	Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	УТХ		
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	УТХ		
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	УТХ		
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	УТХ		
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	УТХ ХШУМХ		
	Хэсгийн дундаж хувь:			
	Хэрэгжилтийн дундаж хувь:			

# БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ХҮСНЭГТ

Хүснэгт 3.6

**Төлөвлөгөөг хянасан:**

**Төсвийн Ерөнхийлөн захирагч**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа I-IV улирал/	Хариуцах нэгж
-----	--	-------	---------------------	-----------------	--------------------	----------------------------	------------------

Стратеги төлөвлөгөөний зорилго 1

1	Зорилт 1						
1.1	Арга хэмжээ						
1.2	Арга хэмжээ						
1.3	Арга хэмжээ						

.....  
(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

(огноо)

Тэмдэг

/.....

**Төлөвлөгөө баталсан:**

**Төсвийн Шууд захирагч**

.....  
(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

(огноо)

Тэмдэг

.....

## Нэг. Эрүүл мэндийн газар

№	Шалгуур үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Тайлбар
1	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насын хүн амын эзлэх хувь			
2	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насын хүн амын эзлэх хувь			
3	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насын эмэгтэйчүүдийн эзлэх хувь			
4	Үмайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насын эмэгтэйчүүдийн эзлэх хувь			
5	Элэгний хорт хавдрын өвчлөлийн эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын хувь			
6	Өрхийн, сумын эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь			
7	Товтолт дархлаажуулалтын хамралтын хувь (товтолын ангиллаар)			
8	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь			
9	Нийт төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь			
10	28-36 долоо хоногтой төрсөн дутуу нярайг амьдроулсан хувь			
11	Төрсний дараах эхний 1 минутад Алгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь			
12	Төрсний дараах эхний 5 минутад Алгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь			
13	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)			
14	Нялхсын эндэгдлийн түвшин (1 000 амьд төрөлт тутамд)			
15	Тав хүртэлх насын хүүхдийн эндэгдлийн түвшин (1 000 амьд төрөлт тутамд)			
16	Амьгүй төрөлтийн түвшин, 1000 төрөлтөд			
17	Өсвөр насын 1 000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин			
18	Үр хөндөлтийн түвшин /15-49 насын 1000 эмэгтэйд ногдох/			
19	1000 жирэмсэнд ногдох үр хөндөлтийн түвшин			
20	15-44 насын 1000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн түвшин			
21	Өсвөр насын 1 000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн түвшин			
22	Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын түвшин К.25 (0-74 насын 10 000 хүн амд)			
23	Давалт ихсэх өвчний шалтгаант нас баралтын түвшин I.10 (0-74 насын 10 000 хүн амд)			
24	Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаант нас баралтын түвшин J.45 (0-44 насын 10 000 хүн амд)			
25	Мухар олгойн шалтгаант нас баралтын түвшин K.35 (0-74 насын 10 000 хүн амд)			
26	Цэсний чулуу, цэсний үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин K.80 (0-74 насын 10 000 хүн амд)			
27	Тархинд цус харвалтын нас баралтын түвшин I.60-62 (0-74 насын 10 000 хүн амд)			
28	Зүрхний шигдээсийн нас баралтын түвшин I.21-I.23 (0-74 насын 10 000 хүн амд)			